



**ДУЛААНЫ IV ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2015 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал
хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59, 60 дугаар зүйл, Төрийн өмчийн хорооны 2015 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 2/672 тоот удирдамжийг үндэслэн "Дулааны IV цахилгаан станц" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас ТОГТООХ нь:

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2015 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 09.30 цагт Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт орших "УБДС" ТӨХК-ийн хурлын танхимд хуралдуулахаар тогтоосугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг нэгдүгээр хавсралтын ёсоор, хувьцаа эзэмшигчдээс санал авах хуудасны загварыг хоёрдугаар хавсралтын ёсоор, хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн маягтын загварыг гуравдугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

3. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг 2015 оны 3 дугаар сарын 20-ны дотор хувьцаа эзэмшигчдэд хүргэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Нарангэрэлд даалгасугай.

4. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2015 оны 3 дугаар сарын 20-ны өдрөөр, саналын хуудас хүлээн авах сүүлчийн өдрийг 4 дүгээр сарын 28-ны өдрөөр тус тус тасалбар болгохоор тогтоосугай.

5. Хувьцаа эзэмшигчдийн танилцах бичиг баримтыг хуулийн хугацаанд бэлэн болгохыг Гүйцэтгэх захирал Ж.Осгонбаатар, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Нарангэрэл нарт үүрэг болгосугай.

6. Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга П.Товуудоржийг томилсугай.



**ДУЛААНЫ IV ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2015 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Компанийн 2014 оны үйл ажиллагааны тайлан,
Гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээний
биелэлт, зорилтот түвшингийн биелэлтийн тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 1.11 дэхь хэсэг, Төрийн өмчийн хорооны 2010 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 166 дугаар тогтоол, Төрийн өмчийн хорооны 2015 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 2/672 тоот удирдамжийг үндэслэн "Дулааны IV цахилгаан станц" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас ТОГТООХ нь:

1. "Дулааны IV цахилгаан станц" Төрийн өмчит хувьцаат компани 2014 онд хэрэглэгчдийг цахилгаан, дулааны эрчим хүчээр найдвартай, тасралтгүй хангах үндсэн үүргээ биелүүлж ажилласан тул Гүйцэтгэх захирал Ж.Осгонбаатартай байгуулсан гэрээний биелэлт, зорилтот түвшингийн биелэлтийг "Хангалттай" гэж дүгнэсүгэй.

2. Компанийн 2014 оны үйл ажиллагааны тайлан, зорилтот түвшингийн биелэлтийг Төрийн өмчийн хорооны хуралдаанд танилцуулахыг Гүйцэтгэх захирал Ж.Осгонбаатарт даалгасугай.

3. Компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг ханган биелүүлэх, санхүүгийн үйл ажиллагааг дээшлүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал Ж.Осгонбаатарт даалгасугай.

ДАРГА



П.ТОВУУДОРЖ



ДУЛААНЫ IV ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2015 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Компанийн 2014 оны жилийн эцсийн
санхүүгийн тайлан тэнцлийн дүнгийн тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 1.11 дэхь хэсэг, Төрийн өмчийн хорооны 2015 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 2/672 тоот удирдамжийг үндэслэн "Дулааны IV цахилгаан станц" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас ТОГТООХ нь:

1. "Дулааны IV цахилгаан станц" Төрийн өмчит хувьцаат компанийн 2014 оны нийт хөрөнгийг 436 675 882,4 мянган төгрөгөөр, үүнээс эргэлтийн бус хөрөнгийг 395 981 513,1 мянган төгрөгөөр, эргэлтийн хөрөнгийг 406 943 369,2 мянган төгрөгөөр, эзэмшигчийн өмчийг 320 190 118,0 мянган төгрөгөөр, нийт өр төлбөрийг 116 485 764,4 мянган төгрөгөөр тус тус санхүүгийн тайлан тэнцлийн дүнг зөвшөөрсүгэй.

2. Компанийн 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн дүнг Хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж батлуулахыг Гүйцэтгэх захирал Ж.Осгонбаатарт даалгасугай.

3. Санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлж ажиллахыг Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

ДАРГА

П.ТОВУУДОРЖ





ДУЛААНЫ IV ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2015 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн
2015 оны зардлын төсвийн тухай

Төрийн өмчийн хорооны 2015 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 2/672 тоот удирдамжийг үндэслэн “Дулааны IV цахилгаан станц” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас ТОГТООХ нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 зардлын төсвийг хавсралтаар зөвшөөрсүгэй.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны зардлын төсвийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж батлуулахыг Төлөөлөн удирдах зөвлөл /П.Товуудорж/-д даалгасугай.

ДАРГА



П.ТОВУУДОРЖ



ДУЛААНЫ IV ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2015 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилахгүй тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.6, 46.8 дахь хэсэг, Төрийн өмчийн хорооны 2015 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 2/672 тоот удирдамжийг үндэслэн "Дулааны IV цахилгаан станц" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас ТОГТООХ нь:

1. "Дулааны IV цахилгаан станц" Төрийн өмчит хувьцаат компани нь 2014 оны санхүүгийн тайлангаар татвар төлсний дараах цэвэр ашиггүй, 4595,5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан тул ногдол ашиг хуваарилах боломжгүй талаар Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулсугай.

ДАРГА



П.ТОВУУДОРЖ